

РУБРИК ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Б.Бат-Оргил

Мэдээллийн системийн менежментийн тэнхим
Санхүү эдийн засгийн дээд сургууль
Монгол улс
bat-orgil.b@ifе.edu.mn

Товч хураангуй – Рубрик үнэлгээний системийг орчин үеийн дэвшилтэд технологи дээр тулгуурлан хөгжүүлэх боломж байгаа эсэхийг СЭЗДС-ийн жишээн дээр багш оюутан гэсэн 2 талт шинжилгээг хийн тодорхойлохыг зорьлоо. Нэгдүгээрт технологийн чиг хандлага, хэрэглэгчийн зан төлөв хаашаа чиглэж байна гэдгийг салбарын судалгаагаар тодорхой болгож хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилсан их дээд сургуулиудын сургалтын үнэлгээний гурван төрлийн аппликейшнийг харьцуулсан судалгаа хийсэн. 62 Багш 422 оюутнуудаас түүвэр бүрдүүлж санал асуулгын аргаар өгөгдөл цуглуулж рубрик үнэлгээний системийн одоогийн хэрэглээний түвшин, хэрэглэхэд тулгарч буй асуудлууд болон хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилсан аппликейшин гаргах боломжийг тодорхойлж улмаар бий болох боломжууд, хүртэж болох үр ашгуудыг нарийн гаргаж дүгнэлт санал зөвлөмжүүдийг гаргалаа.

Түлхүүр үг – Хөдөлгөөнт төхөөрөмж, Аппликейшин

I. ОРШИЛ

Судалгаа хийх болсон шалтгаан

Мэдээлэл технологийн хөгжил асар хурдацтай явагдаж байгаа өнөө үед аж ахуй нэгж байгууллагууд өөрийн бизнесдээ мэдээлэл технологийн хүчийг ашиглаж хэрхэн төсөөлснөөсөө илүү боломжуудийг бүрдүүлж болохыг ойлгох нь чухал болоод байна. Тэгвэл боловсролын салбарт тэр дундаа их дээд сургуулиудын хувьд зах зээл дээр чанартай боловсон хүчин бэлтгэн гаргахын тулд мэдээллийн технологийг зөв ашиглах нь маш их үр дүн авчирал боломжтой юм. Сүүлийн жилүүдэд байгууллагууд хэрэглэгчтэйгээ хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилсан аппликейшнээр харилцах явдал ихээр ажиглагдах болсон нь хэрэглэгч буюу хүмүүсийн хэрэглээ тэр чиглэлд шилжиж байгааг давхар харуулж байгаа юм. Тиймээс их дээд сургуулийн хувьд сургах үйл явцыг дэмждэг технологийг нэвтрүүлж чадвал сургуулийн эрхэм зорилгодоо хүрэх улмаар олон улсын жишигт хүрч ажиллахад маш том түлхэц болох юм. Сургуулийн магадлан итгэмжлэлийн ажлын хүрээнд хичээл бүр дээр оюутны ажиллаварыг үнэлэх рубрик үнэлгээний матрицыг боловсруулсан байдаг. Багш нарын дунд рубрик үнэлгээний матрицыг ашиглах явдал бага нөгөө талаас оюутнуудын рубрик үнэлгээний талаарх ойлголт муу байгаа нь ажиглагдах болсон тул оюутан багшийн хоорондын сургах үйл явц түүнийг дүгнэх үнэлгээ өгөх арга зүйг нарийн судалж хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилсан аппликейшнээр энэхүү асуудлыг шийдвэрлэх

боломжтой эсэхийг тодорхойлох зорилготойгоор тус судалгааны ажлыг хийж байна.

Салбарын судалгаа: Технологийн хөгжлийн чиг хандлага

Infinite Solution компаниас гаргасан судалгаагаар монголын хөдөлгөөнт төхөөрөмжид суурилсан аппликейшны зах зээлээс олох орлого 2007 оноос 2010 оны хооронд жил бүр 2-5 дахин өсч байсан бол 2010 оноос хойш өнөөдрийг хүртэл 50-100% нэмэгдсэн байна.[1]

Зураг 1. Хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилсан аппликейшнээс олох орлого



Монгол улсад ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо сүүлийн 3 жилд хурдацтайгаар нэмэгдэж 20 мянгаас 300 мянга болж өссөн байна. Энэ нь хөдөлгөөнт төхөөрөмж хэрэглэгчдийн зах зээл хангалттай өсөлттэй байна гэж хэлж болно.

| | Нэр | Easy assessment | Teacherkit | Edmodo |
|----|-----------------------------|---|--|--------|
| 1. | Үнэлгээ өгөх боломжтой эсэх | ✓ | ✓ | ✓ |
| | | 1.Өөрийн хүссэн шалгуур, төрлөө EXCEL дээр оруулна. 2.CSV форматыг дэмжиж ажиллана. 3.DROPBOX-той ажиллана. | | |
| 2. | Ирц бүртгэх боломж | ✗ | ✓ | ✗ |
| | | TeacherKit application нь ирц авдагаараа илүү давуу талтай. 1. Хичээлийн дугаар, цагийг сонгоно 2. Тухайн сурагчийн нэрийг сонгоод дээр нь дарахад тасалсан, ирсэн, чөлөөтэй гэсэн сонголтууд дарах болгонд солигдон гарч ирнэ. | | |
| 3. | Дүрс бичлэг зураг оруулах | ✓ | ✗ | ✓ |
| | | Easy assessment нь тухайн ангийн группт зураг, бичлэг, файл зэргийг оруулж болно | Edmodo нь харин тухайн оруулсан материалуудыг нэгтгэн архивладаг. Түүнээсээ файл, зураг,бичлэгийн нэрээр шүүн хайж болдог. | |
| 4. | Dropbox e-mail-р түгээх | ✓ | ✓ | ✗ |
| | | Оюутнуудын авсан дүнг e-mail, dropbox ашиглан илгээх үйлдэл хийнэ. | Харин TeacherKit нь зөвхөн Dropbox-руу оруулах үйлдлийг хийнэ. | |
| | | ✓ | ✗ | ✓ |

| | | | | | |
|-----|--|--|---|---|---|
| 5. | Тэмдэглэл хөтлөх | Сурагчдын хийсэн, явуулсан бие даалт, бүтээлч ажил зэрэгт зөвлөгөө, шүүмж зэрэг зүйлсийг оруулж болно. | | | |
| 6. | Зан төлөвийг үнэлэх | TeacherKit, Edmodo гэсэн хоёр application нь сурагчдын суралцах явцад гаргасан зан төлөв (эерэг, сөрөг тал), амжилт зэргийг тусгаж болно. | ✗ | ✓ | ✓ |
| 7. | График дүрслэл | TeacherKit сурагчдын явцын дүнгүүд, зан төлөв, ирц, гүйцэтгэл зэрэгт үнэлгээ өгсөний эцэст нь график дүрслэлээр нэгтгэн харуулдаг. | ✗ | ✓ | ✗ |
| 8. | Төлөвлөгөө хийх | TeacherKit болон Edmodo хоёр нь цаг сэдвийн төлөвлөгөө хийдгээрээ давуу талтай. Edmodo нь сар, жилээр календарчилсан төлөвлөгөөг хийхэд илүү тохиромжтой. TeacherKit нь өдрөөр болон цагаар төлөвлөгөө хийхэд тохиромжтой | ✗ | ✓ | ✓ |
| 9. | Шинэ анги нээх | Дээрх 3 application-ы нэг адил тал нь нэг багш хэд хэдэн анги үүсгэж болно. Харин EDMODO –ийн ялгарах давуу тал нь нэг анги дотор хэд хэдэн группыг дахин нээж болно. | ✓ | ✓ | ✓ |
| 10. | Хэл сонгох боломж | Easy Assesment, TeacherKit, Edmodo-ийн хамгийн том давуу тал нь олон хэл дээр хэрэглэж болдог (Жич: Түгээмэл хэлнүүд багтана. Монгол хэлний сонголт байхгүй.) Хэлнүүд: Англи, Герман, Франц, Орос, Солонгос, Япон, Испани, Итали, Араб гэх мэт. | ✓ | ✓ | ✓ |
| 11. | Сурагчдын дүнг эцэг эх нь хянах боломж | TeacherKit, Edmodo хоёр нь зөвхөн багш сурагчдад зориулсан application биш бөгөөд тухайн application-ыг хэрэглэж буй сурагчдын эцэг эхчүүдэд зориулсан булантай. Edmodo: Тусгай кодын туслалцаатайгаар эцэг эхийн account нээн хүүхдийнхээ ирц, зан төлөв, шалгалт бие даалтын дүнг хянах боломжтой. TeacherKit: Багш-Эцэг эхийн хоорондын харилцааг сайжруулдаг бөгөөд багш сурагчийн тухай мэдээллийг эцэг эхэд нь шууд e-mail зэрэг харилцаа хобооны зүйлсээр холбогдон хүргэдэг. | ✗ | ✓ | ✓ |

Дээрх гурван аппликейшнийг харьцуулаад үзэхэд оюутнуудын хийсэн ажиллавар, бие даалт, бүтээлч ажил зэрэгт зөвлөгөө, шүүмж өгч тэмдэглэгээ оруулах мөн суралцах явцад гаргасан зан төлөв (эерэг, сөрөг тал), амжилт зэргийг тусгаж болдог нь оюутнуудын хувьд хувийн хэргийг баяжуулах мэдээллийн бааз үүсэх, багш нарын хувьд оюутнуудад өгсөн зөвлөгөө зэрэг нь байнга хадгалагдах давуу талуудтай юм. Бас явцын дүнгүүд, зан төлөв, ирц, гүйцэтгэл зэрэгт үнэлгээ өгсөний эцэст нь график дүрслэлээр нэгтгэн харуулдаг нь оюутнууд, багш, удирдлагуудад шийдвэр гаргалтанд туслах маш чухал мэдээллийн эх үүсвэр болох юм.

Онолын судалгаа

Аливаа даалгаварын гүйцэтгэлийг хэмжих хэмжүүр үзүүлэлтүүдийн зарим нь хэмжигдэхүйц /шалгалт г.м/, зарим нь хэмжигдэхэд төвөгтэй үзүүлэлтүүд байдаг бөгөөд жишээ нь: бие даалт нь дотроо эссэ, реферат, кейс гэх мэт олон төрөлтэй тул хэмжихэд бэрх байдаг. Энэ хэмжихэд төвөгтэй үзүүлэлтүүдийг рубрик ашиглаж нэг үнэлгээний загварт оруулах нь ямар нэг хүний хувийн үзэмжээс шалтгаалахгүйгээр бодитой үнэлгээнүүд гарч ирэх боломжийг олгодог.

Нэр томъёоны хүрээнд оноогоор дүгнэх рубрик гэдэг нь “тодорхой хүн амын гүйцэтгэлийн стандарт” гэсэн

үг (*The National Science Education Standards*) буюу уламжлалт утга нь “Баримт бичгийн толгой хэсэг” *rubrica* гэсэн Латин үг юм. 1970 оны дундуур хэрэглэгдэж эхэлсэн ба 1970 оны сүүлээр Нью-Йорк мужийн Регентийн зохион бичлэгийг үнэлэхэд ашигладаг ба энэхүү шалгалт нь үнэлгээ өгөгчдийг олон хэмжээст стандартчилагдсан хөгжингүй үнэлгээ ашиглан нэгдмэл үнэлгээ өгөхийг шаарддаг байсан байна.

Үнэлгээний рубрик-ийн бүрэлдэхүүн

Үнэлгээний рубрикт гүйцэтгэлийн үнэлгээ, хэмжигдэж буй үзүүлэлтийг харуулсан тодорхойлолт болон жишээ гэх зэрэг нэг болон түүнээс дээш хэмжигдэхүүнтэй байдаг ба хэмжигдэхүүн бүрт тохирсон үнэлгээний шатлал байна.

Хэмжигдэхүүнүүд нь ерөнхийдөө **шалгуур**, үнэлгээний шатлалтай **түвшин**, тодорхойлолтуудтай **тодорхойлогч**-с бүрдэнэ.

Херман, Асбатчер, болон Винтерс нар үнэлгээний рубрик-ийн дараах элементүүдийг гаргасан байна.[2]

- Сурагчдын хариултыг дүгнэх үндэс болсон нэг ба түүнээс дээш хэв шинж болон хэмжигдэхүүнүүд байна.
- Хэв шинж ба хэмжигдэхүүн болгоны утгыг тодруулах тодорхойлолт болон жишээнүүд
- Хэмжигдэхүүн бүрийг хэрхэн үнэлэх талаарх шаталсан утга
- Түвшин бүрийн загвар болон жишээг хавсаргасан тодорхой гүйцэтгэлийн түвшний төгс байдлын стандарт

1980 оноос хойш маш олон үнэлгээний рубрикууд график хэлбэрээр, торон сүлжээ хэлбэрээр гарч ирсэн. Үнэлгээний рубрик-ийн үр ашиг нь торон сүлжээний үр ашгийг давсан гэж судалгаа нотолж байна. [2]

II. ЭМПИРИК СУДАЛГАА

Судалгааны ажлын зорилго


Рубрик үнэлгээний системийн одоогийн хэрэглээний түвшинг тодорхойлж хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилсан аппликейшн хэлбэрээр гаргахад хүрч болох үр ашгийг СЭЗДС-н бодит мэдээлэл дээр тулгуурлан гаргахад оршино.

Зорилтууд

- Рубрик үнэлгээний системийн өнөөгийн хэрэглээний түвшинг тодорхойлох
- Оюутны рубрик үнэлгээний системийн талаарх ойлголтыг тодорхойлох
- Багш оюутныг хэр оновчтой үнэлдэг эсэхийг тодорхойлох
- Рубрик матрицыг ашиглахад тулгардаг бэрхшээлийг тодорхойлох
- Инфосисд тулгуурлан рубрик үнэлгээний матрицыг аппликейшн хэлбэрт оруулах боломжийг тодорхойлох
- Аппликейшн нэвтрүүлснээр хүрч болох боломжуудийг тодорхойлох


1. Рубрик үнэлгээний матрицын хэрэглээг тодорхойлох

График 1. Рубрик үнэлгээний матрицын ашиглалт



Нийт багш ердөө 30% нь рубрик үнэлгээний матрицыг идэвхтэй ашиглаж байхад үлдсэн 70% нь бараг ашигладаггүй ба ер нь л ашигладаг гэсэн хариулт өгсөн байна.

График 2. Рубрик үнэлгээний матрицын хэрэглээний хоёр талт үр дүн/эрдмийн зэрэг, албан тушаал, нас/




Эрдмийн зэргээр хэрэглээг харвал докторын зэрэгтэй багш нар ашиглалтын түвшин харьцангуй тогтворгүй огт ашигладаггүй багш болон байнга ашигладаг багш нарын тоо ойролцоо байхад мастерийн зэрэгтэй багш нарын дийлэнх нь бараг ашигладаггүй ба ер нь л ашигладаг гэсэн байна. Харин бакалаврын зэрэгтэй багш нарын хувьд гурав багш тутмын хоёр нь нэлээд ашигладаг буюу байнга ашигладаг гэсэн нь энэ зэрэгтэй багш нарын дунд хэрэглээ сайн байгааг харуулж байна.

Дадлагажигч багш нарын хувьд рубрик үнэлгээний матрицыг ашиглах нь дундаж дунджаас дээгүүр үзүүлэлттэй байхад багш, ахлах багш нарын хувьд бараг ашигладаггүй ба ер нь ашигладаг гэдэгт өндөр үзүүлэлттэй байгаа нь дундаж буюу дунджаас доогуур үзүүлэлттэй байна гэж болно. Харин дэд профессор, профессорын хувьд харьцангуй тогтворгүй үзүүлэлт харагдаж байгаа нь эрдмийн зэргээр үнэлсэнтэй адил үр дүн гарч байна.

Насны хувьд авч үзвэл 25-с доош буюу залуу багш нар болон 36-45 насны багш нарын хувьд хэрэглээний түвшин адил дундаж буюу дунджаас дээгүүр үзүүлэлттэй байхад 26-30 буюу 31-35 насны багш нарын хувьд хэрэглээний түвшин дундаж буюу дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Харин 46-55 настны багш нарын хувьд хэрэглээний түвшин харьцангуй тогтворгүй буюу бараг ашигладаггүй болон байнга ашигладаг багш нарын тоо ойролцоо үр дүнтэй байна. Тэгвэл 56-дээш насны багш нарын рубрик үнэлгээний матрицыг дундаж үзүүлэлттэй ашигладаг нь тус тус харагдаж байна.

График 3. Үнэлгээний матрицын хэрэглээ оюутаны зүгээс

Суралцдаг хөтөлбөр Суралцдаг курс Суралцдаг мэргэжил



Дээрх гурван графикаас харахад адил тархалттай байгаа нь оюутнууд суралцдаг хөтөлбөр, курс, мэргэжил

үл хамааран бүгд багш ажиллаварыг үнэлэхдээ тодорхой хэмжээнд рубрик матриц ашигладаг гэсэн байна. Гэхдээ энэ нь оюутнуудын рубрик үнэлгээний матрицын талаарх ойлголттой шууд хамааралтай юм.


2. Оюутны ажиллаварыг хэр оновчтой үнэлдэг эсэхийг тодорхойлох

График 4. Оюутан тус бүрт үнэлгээ өгөх



Багш багаар хийсэн ажиллаварыг шалгах явцад оюутан тус бүр дээо үнэлгээ төдийлэн сайн хийж чаддаггүй нь харагдаж байна. Нийт багш нарын 15% нь огт чаддаггүй, 65% нь зарим тохиолдолд чаддаггүй байгаа нь бүрэн үнэлгээ өгч чаддаг гэсэн 20%-тай харьцуулахад маш муу үзүүлэлт юм.


График 5. эрдмийн зэрэг болон багшилж буй жил



Багийн ажиллаварыг үнэлэх үед оюутан тус бүрийг үнэлж чаддаг эсэхэд эрдмийн зэрэг болон багшилж буй жилээр авч үзвэл эрдмийн зэргээсээ үл хамааран багш нар оюутан бүрт зарим тохиолдолд үнэлгээ өгч чаддаггүй байна. Харин ажилсан жилээр авч үзвэл жил ахих тусам багийн ажил хамгаалах үед оюутан бүрийг үнэлэх чадвар буурч байгаа нь харагдаж байна.

График 6. Оюутны үнэлгээний сэтгэл ханамж

Суралцдаг хөтөлбөр Суралцдаг курс Суралцдаг мэргэжил



Оюутнууд суралцдаг хөтөлбөр, курс, мэргэжилээс үл хамааран багшийн өгсөн үнэлгээнд сэтгэл хангалуун байдаг ба зөв үнэлдэг гэж үзсэн байна. Гэхдээ энэ нь багийн гишүүдийн оролцоо болон оюутан тус бүр дээр хийсэн үнэлгээ зөв гэсэн дүгнэлт биш юм. Учир нь багийн бүх гишүүд адил дүн авдаг явдал үнэлгээг нарийн хийдэггүй гэдгийг харуулж байна.

3. Рубрик матрицыг ашиглахад тулгардаг бэрхшээлүүдийг тодорхойлох

График 7. Рубрик матрицын тохиромжтой эсэх




Рубрик үнэлгээний матрицаар оюутны ажиллаварыг үнэлэхэд тохиромжтой байдал дундаж буюу түүнээс доогуур үзүүлэлттэй байгаа нь ашиглахад асуудлууд байгааг харуулж байна.

Тохиромжгүй гэж үзсэн багш нарын шалтгааныг тодруулбал үнэлэхэд хэцүү, хугацаа их ордог, амждаггүй гэх асуудлууд нь рубрик ашиглаж дүгнэх процесс нь хугацаа их ордог ажиллагаатай ба түүнийг хялбаршуулах шаардлагатай байгааг харуулж байна. Мөн багийн бүх оюутнуудыг нэг онооноор дүгнэх нь тохиромжгүй гэж үзсэн байна.

1-10 жил ажилласан багш нарын хувьд ажиллаварыг үнэлэхэд төвөгтэй, цаг хугацаа шаарддаг нь асуудал гэж үзсэн бол 11-с дээш жил ажилласан багш нар цаасан учир үрэгдэх гээгдэх гэх мэт болон үнэлгээний задаргааг оюутанд танилцуулахад бэрхшээлтэй зэрэг нь асуудал болдог байна.


4. Аппликейшн хэлбэрээр гаргах боломжийг тодорхойлох

График 8. Ажиллаварын задаргаа харах шаардлага Суралцдаг хөтөлбөр



Дээрх гурван графикаас харахад бүгд адил тархалттай байгаа ба оюутнууд суралцдаг хөтөлбөр, курс, мэргэжилээсээ үл хамааран бие даалтын үнэлгээний задаргаагаар танилцах хүсэлтэй байдаг байна. Тиймээс тус задаргаа нь багш, хичээл бүр дээр нэгдсэн нэг стандарттай оюутан хүссэн үедээ багшийн оролцоогүй харах боломжийн бүрдүүлэх шаардлага байгааг харуулж байна.


График 9. Багш нарын насны ангилалаар аппликейшн нэвтрүүлэх боломж



Багш нар насны ангиллаас үл хамааран ухаалаг төхөөрөмжинд суурилсан аппликейшн хэрэглэх боломжтой ба ашиглах магадлал маш өндөр байна. Энэ нь нас ахимаг багш нар технологийн салбараас хол

гэх аюулыг үгүйсгэж байна. Мөн аппликейшн хэлбэрээр дүнгийн системийг шилжүүлбэл хэрэгтэй гэж үзсэн байна.

График 10. Аппликейшн хэрэглэх хандлага (курс, хөтөлбөр, мэргэжилээр)



Дээрх гурван графикаас харахад ижил тархалттай ба Оюутнууд суралцдаг курс, хөтөлбөр, мэргэжилээс үл

хамааран аппликейшн хэлбэрээр үнэлгээний системийг харах боломжтой бол идэвхтэй ашиглах нь харагдаж байна.

Хүснэгт 1. Аппликейшнний хүчин зүйлсийн үнэлгээ (багшилж буй жилээр)

| Таны бодлоор энэхүү аппликейшнний хувьд дараах хүчин зүйлс хэр чухал вэ? * СЭЗДС-д багшилж буй жил Crosstabulation | | | | | |
|--|-------------------------|-----|------|-------|--------|
| Хүчин зүйлс | СЭЗДС-д багшилж буй жил | | | | |
| | 1-3 | 4-6 | 7-10 | 11-15 | 16-с д |
| Цаг хугацаа хэмнэдэг байх нь | | | | | |
| Хэрэглэхэд хялбар байх нь | | | | | |
| Утас, таблет зэргээ мартсан ч дурын тухайн аппликейшн суусан төхөөрөмжөөс холбогдох боломжтой байх нь | | | | | |
| Ирц, семинар, шалгалт гэх зэрэг бусад дүнгүүдийг нэгэн зэрэг оруулах боломжтой байх нь | | | | | |
| Зураг, видео гэх мэт нэмэлт файл хавсаргах боломжтой байх нь | | | | | |

1-3 жил ажилласан шинэ багш нарын хувьд уг аппликейшн нь утас, таблетар хязгаарлагдахгүй дурын төхөөрөмжөөс ажиллах болотжтой ба ирц семинар шалгалт зэрэг бусад бүх дүнгүүдийг нэгэн зэрэг оруулах боломжтой байхыг чухалчилсан бол 4-6 жил ажилласан багш нар хэрэглэхэд илүү хялбар байхыг, 7-15 жил ажилласан багш нар цаг хугацаа хэмнэдэг байхыг тус тус чухалчилсан нь дээрх хүчин зүйлүүдийг бүгдийг шингээсэн аппликейшн байх шаардлагыг харуулж байна. Оюутнуудын хувьд суралцдаг хөтөлбөр, курсээс үл хамааран хэрэглэхэд хялбар, ажиллаварын үнэлгээний дэлгэрэнгүй задаргааг харах боломжтой байх, ирц семинар шалгалт дүнгүүдийг зэрэг харах боломжтой байх зэргийг чухалчилсан бол цаг хугацаа хэмнэдэг байх нь төдийлэн чухал биш нь харагдаж байна. Учир нь оюутнууд үүнийг зөвхөн харах хэлбэрээр ашиглахтай холбоотой гэж дүгнэж болно.

III. ЭМПИРИК СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ


Рубрик үнэлгээний матрицын хэрэглээний нэгдсэн дүгнэлт:

Нийт сургуулийн багш нарыг авч үзвэл гурван үндсэн бүлэгт авч үзэж болно.

- 1) Шинээр ажилд орсон дадлагажигч албан тушаалтай, бакалаврын зэрэгтэй 25 буюу түүнээс доош насны багш нар
- 2) Ажил ороод нэлээн хэдэн жил болсон багш болон ахлах багш албан тушаалтай, мастерын зэрэгтэй, 26-35 орчим насны багш нар
- 3) Олон жил ажилласан, дэд профессор профессор цолтой, докторын эрдмийн зэрэгтэй 35-45 насны багш нар

Дээрх 3 ангилалд хэрэглээний түвшин өөр өөр байна.

| | | |
|----------|---|---|
| <p>1</p> | <p>Шинээр ажилд орсон бүх юм шинэлэг эрч хүчтэй, мөн хариуцлагатай нөгөө талаас туршлагагүй өөрийн арга барилаа сайн олоогүй шинжтэй учир оюутны бие даалтыг үнэлэхдээ рубрикийг сайн ашигладаг гэсэн үр дүн гарсан</p> | <p>Оюутнуудын хувьд рубрик үнэлгээний системийн талаар сайн ойлголтгүй багшийн ажиллаварууд үнэлэхдээ ашиглаж буй хувийн арга барилыг рубрик үнэлгээний систем гэсэн ойлголттой</p> |
| <p>2</p> | <p>Ажилдаа гаршсан, орчинтойгоо дассан, өөрийн гэсэн тогтсон арга барилаар үнэлэх хандлагатай рубрик үнэлгээний системийг төдийлэн сайн ашигладаггүй.</p> | |

| | | |
|--|---|--|
|  <p>3</p> | <p>Оюутныг үнэлэх чадвар сайн эзэмшсэн туршлагатай тул зарим тохиолдолд рубрик ашиглахгүй шууд үнэлэх чадвартай зарим тохиолдолд маш хариуцлагатай яс рубрик үнэлгээний систем хэрэглээд сурчихсан.</p> | <p>байгаа нь багшийг рубрик үнэлгээний матриц маш сайн ашигладаг гэсэн үр дүн гаргахад хүргэсэн нь алдаа болж байна.</p> |
|--|---|--|

| | |
|--|---|
| <p>оруулах болон шалгах, засварлах боломжтой</p> <ul style="list-style-type: none"> • Багшийн урьдчилсан үнэлгээ цаасан болон өөр ямар нэгэн програм дээр хадгалагдах бус үнэлгээний системд найдвартай хадгалагдах боломжтой • Оюутан бие даалтын үнэлгээний задаргааг заавал багшаас очиж асуухгүй халаасан дахь утсаа ашиглан мэдэх боломжтой • Багш нарын хичээл, оюутан бүрт өгсөн шүүмж, зөвлөмжүүд хадгалагдах боломжтой • Хичээлийн дүн болон багш нарын нэмэлтээр өгсөн тэмдэглэлүүдийг нэгтгэн оюутан бүр дээр график гаргах боломжтой | <p>сайжрах</p> <ul style="list-style-type: none"> • Ажиллаварыг үнэлэх нэгдсэн нэг рубрик матриц ашигласнаар сургалтын түвшин олон улсын стандартад орох • Сургуулийн удирдлагуудад шийдвэр гаргалтанд туслах мэдээллээр хангах боломжтой • Оюутнууд сурсан хугацааны сурлагын ахиц, амжилтуудыг график дүрслэлээр гаргаж багш нарын өгсөн шүүмж сайшаалаас хувийн хэрэгээ баяжуулах бүрээ боломжтой • Гарц үр дүнгийн тайланг илүү нарийн хийх боломжтой |
|--|---|

Оюутны ажиллаварыг үнэлэх үнэлгээний нэгдсэн дүгнэлт

Багш оюутнуудын ажиллаварыг үнэлсэн үнэлгээнд оюутнууд сэтгэл хангалуун байдаг бол багш нарын зүгээс багийн ажиллаварыг шалгах үед оюутан бүрийг үнэлж чаддаггүй баг нийтэд нэг дүн өгөх хандлагатай байдаг байна. Харин ажилсан жил өсөх тусам оюутан бүрт үнэлгээ өгөхөд илүү хүндрэлтэй болж байгаа нь магадгүй туршлага гэхээсээ илүү настай холбоотой байж болох юм. Үүнээс дүгнэхэд багш нар нэгдсэн нэг рубрик ашиглахгүй байсан ч үнэлгээгээ өөрсдийн туршлага дээр үндэслэн өгөхөд алдаа гарахгүй байгаа боловч энэ нь гарц үр дүнгийн тайланд нөлөөлж улмаар сургалтын систем алдагдахад хүргэж болох аюултай юм. Өөрөөр хэлбэл технологгүй үйлдвэрлэлтэй зүйрлэж болох юм.

Рубрик үнэлгээний матрицыг ашиглахад тулгардаг бэрхшээлүүдийн дүгнэлт

| Үнэлгээ өгөх үйл явц | Сул талууд бэрхшээлүүд |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> • Ажиллаварын илтгэлийг сонсох • Тэмдэглэгээ хийх • Ажиллаварын тайланг хурааж авах • Тайлантай уншиж танилцах • Тайланд үнэлгээ өгөх • өгсөн үнэлгээнүүдийг excel програмд оруулж тооцоолол хийх • гарсан дүнг инфосид шивж оруулах • оюутнуудад ажиллаварын үнэлгээний задаргааг танилцуулах | <ul style="list-style-type: none"> • Оюутанд үнэлгээ өгөхөд маш олон програм ашигладаг • Эсвэл ямарч тооцоололгүй багшийн өөрсдийн гаргасан аргазүйгээр дүгнэгддэг • Цаг хугацаа их ордог • Цаасан тэмдэглэгээ хаягдах үрэгдэх тохиолдох эрсдэлтэй |

Свог шинжилгээ

| Давуу тал | Боломж |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Багш оюутнуудын дунд ухаалаг утасны хэрэглээ өндөр | <ul style="list-style-type: none"> • Дотоод нөөцөө ашиглан хөгжүүлэх боломжтой • Боловсролын салбарт анхдагч болох |
| Сул тал | Аюул |
| <ul style="list-style-type: none"> • Багш оюутан бүр ухаалаг утастай байх нь хувийн асуудал • Хараа муудах аюултай • Мэдээллийн нууц утсаар дамжин алдагдах | <ul style="list-style-type: none"> • Хүний дадал зуршил • Цаасан хэрэглээний дадал |

Аппликейшн хэлбэрээр гаргах боломж үр ашгийн нэгдсэн дүгнэлт

Аппликейшн хэлбэрээр гаргахад багш болон оюутны зүгээс ашиглахгүй дэмжихгүй байх хүчтэй шалтгаан судалгаагаар гараагүй. Хэрвээ хөдөлгөөнд төхөөрөмжинд суурилсан аппликейшн гаргахаар бол багш оюутны хэрэгцээг бүрэн хангахуйц байх шаардлагатайг хүчин зүйлийн судалгаанаас тодорхой харагдсан.

| Хүртэж болох боломжуудыг дүгнэхэд: | Дээрх боломжуудаас хүртэж болох үр ашгийг дүгнэхэд: |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Багш оюутны ажиллаварыг дүгнэхэд илтгэл тавих цаг мөчид үнэлгээ өгөх боломжтой • Ирцийн оноо хичээл эхлэх цаг мөчид системд орох боломжтой • Багш хаана ч байсан оюутны дүнг ердөө халаасан дахь утсаа ашиглан | <ul style="list-style-type: none"> • Оюутны багийн ажиллаварт хандах хандлага оролцоо нэмэгдэх замаар сурлагын үзүүлэлт өсөх • Багшийн техник ажиллагаа багасан замаар бүтээмж дээшлэх • Оюутны хичээл таслалт, хичээлд хариуцлагатай хандах хандлага |

IV. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Олон улсын магадлан итгэмжлэлийн хүрээнд хийгдсэн Рубрик үнэлгээний матрицын аргазүй багш, удирдлагуудын дунд хэрэглээ болж чадахгүй байгаа нь ажиглагдаж улмаар асуулгын аргаар тус таамгийг шалгахад нийт багш нар оюутны ажиллаварыг үнэлэхдээ туршлага дээрээ үндэслэсэн тус тусын арга барилаар үнэлдэг нь тодорхойлогдсон. Мөн оюутнууд рубрик үнэлгээний матрицын талаар мэдлэг маш дутмаг байдаг нь судалгаагаар гарсан. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд санал болгосон хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилсан аппликейшнийг нэвтрүүлэхэд хүчтэй эсэргүүцэл тулгарахгүй нь судалгаанаас гарсан боловч зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай аюулууд гарч ирсэн. Үүнд ихэвчлэн хувь хүний онцлог болон хүний дадал зуршлын асуудлууд байсан ба цаасан хэрэглээнд дассан сэтгэлгээ, ухаалаг утас хэрэглэх нь хувь хүний сонголт, үнэлгээ хийхэд утаснаас илүү таблет тохиромжтой, жижиг дэлгэц их ашигласнаар багш нарын хараазүйд нөлөөлөх зэрэг болно. Дээрх аюулууд нь нэвтрүүлснээр хүрч болох боломжууд түүнээс хүртэж болох үр ашгуудтай харьцуулахад тус технологийн хөгжүүлэлтийг хийхгүй байх хүчтэй шалтгаан болохгүй юм. Учир нь тус хөгжүүлэлтийг хийснээр багш нарын ажил үүргийн хамгийн их цаг ордог гол хэсгийг хялбаршуулж илүү боломжтой болгосноор багш нар эрдэм шинжилгээний ажил хийх, өөрийгөө хөгжүүлэх тал дээр илүү төвлөрч улмаар судалгаанд суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлэхэд ач холбогдолтой юм. Оюутнуудын хувьд сурах хугацааны өөрийн ахиц дэвшил, сурсан гүйцэтгэл зэрэг нарийн мэдээллээр хувийн хэргээ баяжуулах, Багш нарын хувьд гарц үр дүнгийн тайлангаа хялбар аргаар богино хугацаанд илүү нарийн гаргах, Сургуулийн захиргаа удирдлагуудад гарц үр дүнг цаг хугацаа алдалгүй хянаж шийдвэр гаргахад туслах мэдээллээр хангагдах зэрэг гурван талт ашиг тустай юм.

V. ЭХ СУРВАЛЖ

[1] Bloomberg TV Mongolia. (2014, 4 10). *Технологи*. Retrieved from Bloomberg TV Mongolia web site: <http://bloombergtv.mn/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB%D1%8B%D0%BD>

[2] Herman, J. L. (1992). *Association for Supervision and Curriculum Development*